



“МИКРОКРЕДИТ ББСБ” ХХК-ийн  
ЗАХИРАЛ Г.БУЛГАНЧИМЭГ ТАНАА

## “САРУУЛ БАЯН УУЛ-АУДИТ” ХХК

Утас: 99093852, 89383852

2021.01.26 № 15  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн мэдээллээс бүрдсэн “МИКРОКРЕДИТ ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар “МИКРОКРЕДИТ ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг бүхий л материаллаг асуудлаар Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагыг бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаархи хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ  
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
Мөнгөн хөрөнгө	119,947,613.14	714,640,939.64
Зээл /Цэврээр/	3,990,886,539.17	4,061,814,523.17
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	440,406,105.02	459,943,900.66
Бусад хөрөнгө	7,829,902.86	7,368,649.30
Үндсэн хөрөнгө	49,482,685.56	75,250,984.61
Нийт хөрөнгө	<b>4,608,552,845.75</b>	<b>5,334,643,997.29</b>
Богино хугацаат өр төлбөр	816,759,250.00	2,125,204,378.77
Урт хугацаат өр төлбөр	600,000,000.00	
Энгийн хувьцаа	2,500,000,000.00	2,500,000,000.00
Хуримтлагдсан ашиг	691,793,595.75	709,439,618.52
Нийт эздийн өмч ба өр төлбөр	<b>4,608,552,845.75</b>	<b>5,334,643,997.29</b>

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
Зээлийн хүүгийн орлого	1,147,246,905.83	1,573,839,390.51
Зээлийн хүүгийн цэвэр орлого	1,147,246,905.83	1,573,839,390.51
Хүүгийн бус орлого	65,646,904.54	41,376,022.00
Хүүгийн зардал	167,285,437.97	410,514,175.02
Үндсэн үйл ажиллагааны зардал	192,172,339.97	258,369,211.80
Болзошгүй эрсдэлийн зардал	84,776,481.59	206,444,341.25
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		48,378,558.36
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		
Нийт ашиг	<b>768,659,550.84</b>	<b>788,266,242.80</b>
Татварын зардал	<b>76,865,955.09</b>	<b>78,826,624.28</b>
Цэвэр ашиг	<b>691,793,595.75</b>	<b>709,439,618.52</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
Мөнгөн орлогын дүн		
Мөнгөн зарлагын дүн		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(96,093,132.24)	594,693,326.50
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	216,040,745.38	119,947,613.14
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	119,947,613.14	714,640,939.64